

DeFacto

INDEPENDENT RESEARCH INSTITUTE

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМЫН ДОТООД

АРДЧИЛЛЫН ИНДЕКС

2020



ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны тайланг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтайгаар Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд боловсруулав. Тайланд илэрхийлэгдсэн агуулга нь судлаачдын хувь хүний үзэл санаа бөгөөд АНУ-ын засгийн газар эсхүл дээрх агентлаг, хүрээлэнгийн албан ёсны байр суурь биш болно.



МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМЫН ДОТООД

АРДЧИЛЛЫН ИНДЕКС

2020

Эрдэнэбилэгийн **Гэрэлт-Од**
Алтанхуягийн **Бат-Оргил**

Бат-Өлзийн **Эрдэнэдалай**
Ганхуягийн **Батхишиг**

АГУУЛГА

УДИРТГАЛ	6
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	9
НАМЫН ДОТООД АРДЧИЛАЛ ГЭЖ ЮУ ВЭ?	10
МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ДОТООД АРДЧИЛЛЫН ИНДЕКС 2020	13
ОРОЛЦОО	16
ӨРСӨЛДӨӨН.....	18
ТӨЛӨӨЛӨЛ.....	20
ИЛ ТОД БАЙДАЛ САНХҮҮЖИЛТ	22
ДҮГНЭЛТ	24
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖУУД	28
ХАВСРАЛТ.....	30

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Намын дотоод ардчиллын индексийн ангилал (Rahat & Shapira, 2016)	11
Зураг 2. Монголын улс төрийн намын дотоод ардчиллын индекс 2020	13
Зураг 3. Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс, 2018-2020 онд.....	14
Зураг 4. Улс төрийн намын гишүүдийн оролцоо, 2019-2020 он (25 оноо)	16
Зураг 5. Улс төрийн нам доторх өрсөлдөөн, 2019-2020 он (24 оноо)	18
Зураг 6. Улс төрийн намын төлөөлөл, 2019-2020 он (16 оноо)	20
Зураг 7. Улс төрийн намын ил тод байдал, 2019-2020 он (35 оноо).....	22

ТОВЧИЛСОН НЭРСИЙН ЖАГСААЛТ

АН	АРДЧИЛСАН НАМ
АНУОУХА	АНУ-ЫН ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ
БНОУХ	БҮГД НАЙМРАМДАХЧУУДЫН ОЛОН УЛСЫН ХҮРЭЭЛЭН
МАН	МОНГОЛ АРДЫН НАМ
МАХН	МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ НАМ
УТНТХ	УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬ
УДШ	УЛСЫН ДЭЭД ШҮҮХ
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
ХҮН	ХӨДӨЛМӨРИЙН ҮНДЭСНИЙ НАМ

УДИРТГАЛ

Шаттшнайдер (1942) “улс төрийн намууд ардчиллыг бий болгосон ба орчин цагийн ардчиллыг намуудгүйгээр төсөөлшгүй” хэмээн хэлсэнчлэн улс төрийн намууд нь гарцаа байхгүй ардчилсан улс төрийн гол оролцогчид билээ. Монгол Улс 1990 оноос хойш тогтвортойгоор олон намын ардчилсан системээр замнаж ирсэн бөгөөд улс төрийн намууд ардчилсан шилжилтэд чухал үүрэгтэй оролцжээ.

Гэхдээ сүүлийн жилүүдэд улс төрийн намуудын ил тод, нээлттэй байдал нь анхаарах нэг чухал асуудал болоод байна. Сүүлд 2020 онд гүйцэтгэсэн залуучуудын санал бодлын судалгаагаар улс төрийн намууд хамгийн тааламжгүй инстүүцээр тодорчээ (БНОУХ, 2020). Улс төрийн намууд нь олон нийтийн байгууллагын хувьд гишүүдээсээ гадна олон нийтэд ч үйл ажиллагаагаа ил тод явуулах ёстой. Гэвч ил тод, хариуцлагатай байдлыг зөвхөн намын гишүүдэд хамаарах дотоод хүрээний асуудал гэж үзэх хандлага намуудын дунд түгээмэл байна.

Намууд улс төрийн намын тухай хуулийн (2005) 5.1.4-т заасны дагуу

“дотоод асуудлаа ардчилсан зарчмыг баримтлан олонхийн саналаар шийдвэрлэх” ёстой. Үүний дагуу нэр дэвшигчээ тодруулах, бодлогоо боловсруулах, намын даргаа сонгохоос эхлээд дотоод дүрэм журамдаа ил тод, нээлттэй, хүртээмжтэй, хариуцлагатай байх зэрэг зарчмыг баримтлах үүрэгтэй. Түүнчлэн уг хуулийн 13-р зүйлд эдгээрийг намын их хурлаараа шийдвэрлэнэ гэж заажээ. Эндээс Монгол дахь намын дотоод ардчиллын хуулийн шалгуур нь гишүүдийн санал хураалтад гэхээсээ илүүтэй намын их хурал, чуулганд суурилсан гэдгийг харж болно.

Сүүлийн жилүүдэд олон улсын байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагуудаас гадна намын гишүүд, лидерүүд ч дотоод ардчиллын ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг онцлон тэмдэглэх болсон. Намуудад дотоод ардчиллыг төлөвшүүлэх нь нийгэмд ардчилсан соёл, үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлэх ач холбогдолтой билээ.

Дефакто Институт Монголын улс төрийн намуудын дотоод ардчилал төслийг хараат бус, бие даасан судлаачид болон Нийгэм, улс төрийн

боловсрол төвтэй хамтран 2018 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн гол зорилго нь Монгол дахь улс төрийн намуудын ил тод, хүртээмжтэй, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх юм. Бид 2020 оны Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын индексээ АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (АНУОУХА)-ийн санхүүжилтээр Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн (БНОУХ)-гийн хэрэгжүүлж буй Залуучууд, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэв. Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсад иргэн төвтэй засаглал хийгээд улс төрийн хариуцлагыг дээшлүүлэх зорилго бүхий ардчилал, засаглалын санаачлага юм. Энэ хүрээнд улс төрийн намуудын шийдвэр гаргах үйл явц дахь залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоог энэ жилийн индексээр нэмж тодрууллаа.

2020 оны 11 дүгээр сарын байдлаар дэлхийн эмэгтэйчүүд парламентын нийт суудлын ердөө 25.1 хувь, сайдын албан тушаалын 20.7 хувь 1 -ийг эзэлж байна. Харин Монгол Улсын хувьд УИХ-ын 76 гишүүний 13 нь эмэгтэй гишүүд байна. Өөрөөр хэлбэл УИХ-

ын нийт суудлын ердөө 17.1 хувийг эмэгтэйчүүдийн төлөөлөл бүрдүүлж байгаа нь бүс нутгийн болон дэлхийн дунджаас доогуур үзүүлэлт юм.

Үүнтэй адил XXI зуун гарснаас хойш дэлхий даяар улс төрийн шийдвэр гаргах түвшин дэх залуусын оролцоо, төлөөллийн тухай ярьж байна. Учир нь залуус бол эмэгтэйчүүдийн дараа орох нийгмийн том бүлэг юм. Тэднийг ирээдүйд амьдрах, өөрчлөлтийг авчрах агент гэж үзэж байна. Ер нь залуусыг оролцуулахгүйгээр залуусын асуудлыг шийдвэрлэж болохгүй юм. Харамсалтай нь, 2016 оны НҮБ-ийн Дэлхийн залуусын илтгэлд дурдсанаар 18-29 насны залуус намын нийт идэвхтэй гишүүдийн 4.1 хувь байна. Мөн Олон Улсын парламентын холбооны 2018 оны Парламент дахь залуусын оролцоо 2016 оноос хойш 30-аас дооших насны төлөөлөл дөнгөж 2.2 хувь байгааг дурджээ.

Харин Монгол Улсад УИХ-ын 2020 оны сонгуульд 30-аас доош насны төлөөлөл сонгогдоогүй, 40-өөс доош насны төлөөлөл дөнгөж 6 нэр дэвшигч сонгогдсон нь 7,9 хувь болж байна. Улс төрийн нам бол сонгуулийн болон сонгуулийн бус үеэр залуус,

эмэгтэйчүүдээс дэмжлэг авах, улмаар улс төрд татан оролцуулж, бүх шатны улс төрийн шийдвэр гаргах байгууллагад сонгогдоход дэмжлэг үзүүлэх үр дүнтэй бүтэц юм. Өөрөөр хэлбэл, нам үйл ажиллагаа, бодлого, үнэт зүйлээрээ дамжуулж залуус, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, төлөөллийг нэмэгдүүлэхэд нөлөөлж чадах цорын ганц улс төрийн байгууллага.

Энэхүү тайлангаар бид олон улс дахь намын дотоод ардчиллын

индексийн үндсэн ойлголт, арга зүйг эхлээд тайлбарлана. Түүний дараагаар энэ оны индексийн гол үр дүн болон Ардчилсан Нам (АН), Монгол Ардын Нам (МАН), Монгол Ардын Хувьсгалт Нам (МАХН), Хөдөлмөрийн Үндэсний Нам (ХҮН)-ын үнэлгээг хийсэн дөрвөн хэмжигдэхүүнийг танилцуулна. Харин тайлангийн сүүлийн хэсэгт уг судалгааны дүгнэлтийг танилцуулах болно.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Бид уг тайланд Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллыг Израйлын Ардчилал Институтын дотоод ардчиллын индексийн арга зүйд тулгуурлан үнэлэв. Бид судалгааны асуулгаа Монголын хууль эрх зүйн орчинд нийцүүлэн гаргасан. Уг асуулгыг эрх зүйн орчинд аливаа өөрчлөлт гараагүй тохиолдолд цаашдаа ч ашиглах юм. Судалгааны баг нам тус бүрээс 5-7 гишүүнтэй хагас бүтэцлэгдсэн ярилцлага хийсэн. Нийт 18 ярилцлага хийсэн. Судалгаанд оролцогчдыг сонгохдоо зорилтот түүврийн арга ашиглан төв, орон нутгийн намын төлөөллийг жигд хамруулсан ба тэдгээрээс 7 нь эмэгтэй, 5 нь залуу гишүүд байв. Өмнө дурдсанчлан энэ удаагийн индекст улс төрийн намын шийдвэр гаргах түвшин дэх залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоог мөн тодруулахаар зорив. Уг тайланг АНУОУХА-ийн санхүүжилттэй, БНОУХ-гийн “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” төслийн хүрээнд боловсруулав. Мөн бид оролцогчдоо сонгохдоо намын дотоод шийдвэр гаргалт, үйл ажиллагаагаа чөлөөтэй, шударгаар ярьж чадах

гишүүдийг ярилцлагадаа хамруулахыг зорьсон болно.

Бид улс төрийн намын гишүүдтэй хийсэн хагас бүтэцлэгдсэн ярилцлагынхаа дараагаар Улсын Дээд Шүүх (УДШ), Улс төрийн намын тухай хууль (УТНТХ), Сонгуулийн тухай хууль (СТХ) зэрэг нээлттэй мэдээллийн эх үүсвэрүүд, намын дотоож журам зохицуулалтыг шүүж намын дотоод ардчилалтай холбоотой гарсан зарим кейсүүдийг судалсан. Мөн уг судалгаагаар улс төрийн намуудын олон нийтэд нээлттэй байдлыг үнэлэх зорилгоор намын албан ёсны вебсайт, нийгмийн сүлжээний хуудсуудыг үнэлсэн.

Судалгааны баг мэдээллээ 2020 оны 10 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд намуудын албан ёсны вебсайт, нийгмийн сүлжээний хуудсууд дээрх мэдээллийг цуглуулав. Энэхүү индекст кэйсүүдийг сонгохдоо улс төрийн нам судлаачид болох Сартори (1976), Мэйнвэринг, Скалли (1995), Дикс (1992), Касал Бертоа (2011) нарын кэйсээ сонгохдоо түлхүү ашигладаг “хамааралтай намууд” (relevant parties) гэх хэмжүүрээр парламентад суудалтай

эсвэл сонгуульд 10-аас дээш хувийн санал авсан намуудыг сонгосон болно. Улмаар энэ жилийн индекст МАН, АН, МАХН, ХҮН зэрэг нийт 4 улс төрийн намыг хамруулав. УИХ-ын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон бусад нам, эвслүүд сонгогчдыг төлөөлөх хэмжээний хангалттай саналын дэмжлэг, суудал аваагүй байна.

Эцэст нь хагас бүтэцлэгдсэн ярилцлага, судалгаа болон экспертийн үнэлгээнд суурилан намуудыг 0-100

хүртэлх (0 оноотой бол ардчилалгүй, 100 оноотой бол дотоод ардчиллын түвшин хамгийн өндөр) оноогоор үнэлэв. Онооны үнэлгээг улс төрийн намын чиглэлээр 5-10 жил дагнан судалсан дөрвөн эксперт өгсөн бөгөөд тэдгээр нь аль нэг намаас хараат бус, бие даасан судлаачид болно. Мөн уг судалгаанд харьцуулалт хийх зорилгоор өмнөх жилийн үр дүнг ашигласан болно.

Намын дотоод ардчилал гэж юу вэ?

Намын дотоод ардчилал буюу “internal democracy within political party”, нам доторх ардчилал буюу “intra-party democracy” хэмээх ойлголт нь намын шийдвэр гаргах бүхий л түвшинд гишүүд, дэмжигчдийг оролцуулах тухай өргөн хүрээний ойлголт юм. Нам доторх шийдвэр гаргах үйл явц хүртээмжтэй байх нь намын дотоод ардчиллын хамгийн чухал хүчин зүйл юм. Хэрэв улс төрийн нам дотоод ардчилалтай бол нэр дэвшигчдээ тодруулах, даргаа сонгох, мөрийн хөтөлбөрөө боловсруулах зэрэг намын бүх шийдвэрүүдэд гишүүд оролцдог, хамтын шийдвэр, дүрмээ

дагаж мөрддөг. Харин нам дотоод ардчилалгүй бол аливаа шийдвэрийг цөөн тооны оролцогчид, эсхүл удирдлага, дарга баталж мөрдүүлдэг.

Судлаачид өнөөг хүртэл намын дотоод ардчиллыг хэмжих тэр дундаа индексжүүлэх хэд хэдэн оролдлого хийж ирсэн. Өнөөг хүртэл намын дотоод ардчиллыг хэмжих хоёр төрлийн индексийг боловсруулжээ. Эхний индекс нь чуулганд суурилсан (assembly-based) болон бүх гишүүдийн саналд суурилсан (plebiscitary) зэрэг намын дотоод ардчиллын хоёр хэлбэрийг хэмждэг. Фон дэм Берж ба Погунтке (2017) нарын боловсруулсан

уг индекс нь “чуулганд суурилсан намын дотоод ардчиллын индекс”, “бүх гишүүдийн санал хураалтад суурилсан намын дотоод ардчиллын индекс”, “нээлттэй санал хураалтай суурилсан намын дотоод ардчиллын индекс” зэрэг гурван төрлөөс бүрдэнэ. Уг судалгаа нь албан ёсны дүрэм журамд тулгуурлан намын дотоод ардчиллын гурван бүрэлдэхүүн (бодлого боловсруулах, намын албан тушаалтнуудыг сонгох, байгууллагын бүтэц, зохион байгуулалт) хэсгийг судалдаг (von dem Berge & Poguntke, 2017).

Харин бидний энэхүү судалгаанд ашигласан индекс нь намуудыг зөвхөн албан дүрэм журмын хүрээнд үнэлэхээс гадна бодит практик, туршлагыг нь үнэлэх зорилготой цогц индекс юм. Бид уг судалгааг 2018 оноос хойш жил тутам хийсэн туршлагадаа үндэслэн намын дотоод ардчиллыг зөвхөн албан дүрмийн хүрээнд шинжилж үнэлгээ

өгөх нь учир дутагдалтай гэж үзсэн. Учир нь улс төрийн намууд бодит байдал дээр дүрэм журмаа мөрдөхгүй байх тохиолдол нийтлэг тулгардаг. Жишээлбэл 2020 оны сонгуулийн өмнө АН-ын удирдлагууд намаас нэр дэвшигчдийг тодруулахдаа намын үндсэн дүрмийг зөрчсөн тухай намын гишүүдийн зүгээс мэдэгдэж байв. Ийм учраас удаах индекс буюу Гидёон Рахат, Ассаф Шапира нарын боловсруулсан индекс нь намуудыг албан дүрмийн хүрээнд шинжлэхээс гадна бодит байдал дээрх дүрэм журмын хэрэгжилтийг авч үздэг учир Монголын нөхцөлд илүү тохиромжтой юм. Уг индексийн арга зүйн дагуу намуудыг 0-100 хүртэлх оноогоор үнэлнэ. Улмаар намуудыг 61-100 оноотой бол “ардчилсан”, 30-60 оноотой бол “хагас ардчилсан”, 0-30 оноотой бол “ардчилалгүй” зэрэг гурав ангилдаг (Rahat & Shapira 2016).

Зураг 1. Намын дотоод ардчиллын индексийн ангилал (Rahat & Shapira, 2016)



Рахат, Шапира (2016) нарын индекс нь оролцоо (30%), төлөөлөл (20%), өрсөлдөөн (20%), хариуцлага (15%), ил тод байдал (15%) зэрэг нийт 5 хэмжигдэхүүнээс бүрддэг. Эдгээр хэмжигдэхүүн нь тус бүрдээ харьцангуй үнэлгээний жин эзэлж буйг харж болно. Манай судалгааны баг индекстээ дээрх үнэлгээнээс ялгаатай үнэлгээг өгөхөөр шийдсэн болно. Жишээлбэл Монголд улс төрийн намууд санхүүгийн тайлангаа олон нийтэд мэдээллэдэггүй. Иймд бид санхүүжилтийн ил тод байдалд илүүтэй ач холбогдол өгсөн болно. Мөн сонгогдсон төлөөллийн

байгууллагуудтай холбоотойгоор ердөө ганц асуулт байсан учир бид хариуцлагын хэсгийг хасч, төлөөлөл хэсэгт нэгтгэсэн. Ийнхүү тус индекс нь оролцоо (25%), өрсөлдөөн (24%), төлөөлөл (16%), ил тод байдал (35%) зэрэг нийт 4 хэмжигдэхүүнээс бүрдэнэ. Мөн бид улс төрийн нам болон сонгуулийн тухай хуулиудад нийцүүлэн зарим асуулгыг өөрчилсөн болно. Улмаар асуулга, хэмжигдэхүүнүүдийг нийцүүлэхийн тулд Монгол Улсын Их Сургуулийн улс төр судлалын профессоруудтай хэлэлцэж дүгнэсэн.

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ДОТООД АРДЧИЛЛЫН ИНДЕКС 2020


Монгол Улс анхны чөлөөт, шударга сонгуулиа 1992 онд зохион байгуулснаас хойш найм дахь удаагийн УИХ-ын ээлжит сонгууль 2020 онд зохион байгуулагдав. Сонгуулийн жилд улс төрийн намуудын үйл ажиллагаа идэвхждэг учир энэ үеэр намын дотоод ардчиллын түвшинг хэмжих бололцоо ихээхэн бүрддэг.

Энэхүү тайлангаар Монгол дахь намын дотоод ардчиллын нөхцөл байдлыг оролцоо, өрсөлдөөн, төлөөлөл, ил тод байдал зэрэг нийт дөрвөн хэмжигдэхүүнд суурилж шинжиллээ. Гурав дахь удаагийн индекс т МАН, АН, МАХН, ХҮН зэрэг УИХ-д суудалтай дөрвөн улс төрийн намыг хамруулав. Монголын улс төрийн намууд энэ оны индекс дунджаар 59.7 (0-100 хүртэлх онооноос) оноотой

байна. Тус индексийн ангиллын дагуу ХҮН-аас бусад гурван томоохон улс төрийн намын аль нь ч “ардчилсан” ангилалд багтаагүй байна. Мөн ХҮН-ын авсан оноо ч ардчилсан ангилалд дөнгөж багтаж буйг энд тэмдэглэх нь зүйтэй. Энэ нь судалгаанд хамрагдсан улс төрийн намуудад дотоод ардчилал хангалтгүй буйг илэрхийлнэ.

Энэ оны индексийн үнэлгээнд багтсан нам тус бүрийн нийт оноог доорх зурагт харуулав. Судалгаанд хамрагдсан дөрвөн нам оролцоо хэсэгт ойролцоо оноотой байгаа бол томоохон хоёр улс төрийн нам болох МАН, АН нь өрсөлдөөн хэсэгт доогуур оноо авчээ. Харин харьцангуй шинэ улс төрийн намууд болох МАХН, ХҮН нь төлөөлөл хэсэгт хамгийн бага оноотой байна.


Зураг 2. Монголын улс төрийн намын дотоод ардчиллын индекс 2020



Нам тус бүрийн өнгөрсөн гурван жилд авсан оноог Зураг 3-т үзүүлэв. Сүүлийн гурван жилд ХҮН-ын оноо тогтвортой өссөн бол МАН, АН, МАХН зэрэг намуудын оноо тууштай өсөөгүйг эндээс харж болно. Энэхүү судалгаанд оролцсон МАН-аас бусад намууд 2019 оны индекс “ардчилсан” ангилалд

багтаж байсан бол энэ жилийн индекс зөвхөн ХҮН 69.6 оноотойгоор “ардчилсан” ангилалд багтжээ. Сөрөг хүчний голлох намууд болох АН, МАХН нь 2019 оны индекс “хагас ардчилсан” ангиллаас “ардчилсан” ангилалд багтсан ч 2020 онд ихээхэн оноо алдсан байна.

Зураг 3. Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс, 2018-2020 онд



Өмнө дурдсанчлан гол сөрөг хүчин болох АН нь оролцоо хэсэгт 3.7 оноо, өрсөлдөөн хэсэгт 2.7 оноо, ил тод байдал хэсэгт 1 оноогоор тус тус буурчээ. Тус намын оролцооны түвшин хангалтгүй байсан нь ийнхүү оноо буурахад нөлөөлсөн бөгөөд бусад намуудад ч ижил дүр зураг ажиглагдав

. Мөн тус нам УИХ-ын сонгуульд нэр дэвшигчиддээ мөнгөний босго тогтоосон нь оноо буурах бас нэгэн хүчин зүйл болсон. Харин МАН-ын хувьд 2019 онд нийт оноогоо амжилттай ахиулсан ч энэ жилийн индекс оноо нь буурснаар гурав дахь жилдээ дараалан тус индекс “хагас

ардчилсан” ангилалд багтаж байна.

Монголын гурав дахь томоохон нам болох МАХН энэ оны индекст хамгийн их буюу 8.5 оноогоор буурсан байна. Тус намын санхүүжилтийн ил тод байдал 2019 онд харьцангуй өндөр түвшинд байсан ч энэ онд санхүүгийн тайлангаа намын гишүүддээ тайлагнаагүйн улмаас оноо ийнхүү буурав. Түүнчлэн намын залуучууд, оюутнууд, эмэгтэйчүүдийн зэрэг дотоодын төлөөллийн байгууллагуудаа татан буулгах шийдвэр гаргаснаар төлөөлөл хэсэгт ихээхэн оноо алдсан.

ХҮН-ын хувьд хэд хэдэн онцлог зүйлс байгааг дурдах хэрэгтэй. Үүнд, цөөн гишүүнтэй, шинээр бойжиж

байгаа, бүтэц, зохион байгуулалт, бүрдэлжилтийн үйл явц өрнөж байгаа улс төрийн хүчин. Тиймээс дотоод ардчиллын судалгаанд нэлээд өндөр оноо авсан байх талтай. Нөгөө талаас гишүүнчлэл цөөн, нүсэр бүтэц, зохион байгуулалтгүй намд дотоод ардчилал бүрдэхэд хялбар байж болох юм.


Бид судалгааны хүрээнд намын дотоод ардчиллын индексийг тодорхойлоход нөлөөлж буй оролцоо, өрсөлдөөн, төлөөлөл, ил тод байдал гэсэн дөрвөн хэсэгт улс төрийн намууд хэдэн оноо авсан болохыг дараагийн хэсэгт авч үзнэ.

ОРОЛЦОО

Улс төрийн оролцоо гэж шийдвэр гаргах үйл явцад шууд ба шууд бусаар нөлөөлөхүйц олон төрлийн үйл ажиллагааг хамрах өргөн хүрээний ойлголт юм. Шийдвэр гаргагчдыг сонгох нь оролцооны нэг хэлбэр бөгөөд төрийн төдийгүй намын түвшний ардчиллын үндсэн зарчим юм (Рахат, Шапира 2016). Энэ утгаараа намын дарга, намаас хууль тогтоох байгууллагад нэр дэвшигчдийг тодруулах, төрийн албанд томилох болон намдоторх бүтцийн байгууллагад гишүүдийг төлөөлөхүйц голлох үүрэгтэй шийдвэр гаргагчдыг хэрхэн сонгож байгааг энэ хэсэгт шинжилсэн. Улс төрийн нам дотоод ардчиллыг

бодитойгоор хэрэгжүүлэхийн тулд гишүүдийн оролцоог зөвхөн албан дүрмийн хүрээнд баталгаажуулахаас гадна бодлого боловсруулах үйл явцад хангах нь чухал юм. Иймээс бодлогын баримт бичгүүдэд хэлбэр төдий бус бодитой оролцоог шинжлэхийн тулд боловсруулах болон батлах үйл явцыг салган авч үзсэн болно. Үүний дагуу намын мөрийн хөтөлбөр, сонгуулийн мөрийн хөтөлбөр болон намаас өрнүүлсэн бодлогын мэтгэлцээнүүдэд намын гишүүд, дэмжигчдийг хүртээмжтэй оролцуулж буй зэргийг шинжиллээ. Тус судалгааны оролцоо хэмжигдэхүүн нь нийт 25 хүртэлх оноотой байна.

Зураг 4. Улс төрийн намын гишүүдийн оролцоо, 2019-2020 он (25 оноо)



Намын гишүүдийн оролцоо хэсэгт судалгаанд оролцсон дөрвөн нам энэ онд ойролцоо оноо авсан байна. Намууд тус хэмжигдэхүүнээр дунджаар нийт 25 онооноос 15.5 оноо авчээ. Зураг 4-т нам тус бүрийн авсан оноог өмнөх оны үр дүнтэй харьцуулан үзүүлэв. 2020 онд МАН оролцоо хэсэгт хамгийн их оноог ахиулжээ. Харин АН-ын хувьд намын даргаа сонгохдоо бүх гишүүдийн саналаар буюу хамгийн хүртээмжтэй оролцооны арга ашиглаж буй нам хэвээр байна. Энэхүү өөрчлөлтийг тус нам 2016 оны сонгуульд ялагдал хүлээсний дараа буюу намын дотоод шинэчлэлийн үр дүнд нэвтрүүлсэн билээ. Тус нам 2019 онд уг хэмжигдэхүүнээр хамгийн өндөр оноог авсан ч 2020 онд намын


шийдвэр гаргах үйл явцад тэр дундаа нэр дэвшигчдийг сонгох үйл явцад гишүүдийн оролцоо хангалтгүй байсан учир оноо нь ихээхэн буурав. Судалгаанд оролцогчдын хариулснаар хэдийгээр орон нутгийн нам сонгуульд нэр дэвшигчдийг санал болгодог ч төв намаас эцсийн шийдвэрийг гаргадаг байна. Улс төрийн намууд сонгуулийн хөтөлбөр боловсруулах үйл ажиллагаанд гишүүдээс санал ажил зохион байгуулдаггүй, гишүүд ч бодлогын мэтгэлцээнд оролцох, байр сууриа илэрхийлэх нь ховор байна. Судалгаанд оролцогчид хэдийгээр сонгуулийн жил байсан ч 2020 онд нам доторх бодлогын мэтгэлцээн огт зохион байгуулаагүй гэж хариулсан.

ӨРСӨЛДӨӨН

Өрсөлдөөн нь оролцооны адил ардчиллын үндсэн, суурь нөхцөл. Гол зарчим нь сонгогчид саналаа өгөх хэд хэдэн сонголттой байхыг шаарддаг (Рахат, Шапира 2016). Энэхүү хэмжигдэхүүнээр намын их хурлаас сонгон байгуулсан төлөөллийн төв байгууллага, удирдах зөвлөл зэрэг намын дотоод бүтцийн байгууллагууд болон намын шийдвэр гаргах албан

тушаалуудын сонгууль хийсэн эсэхийг шинжилсэн. Түүнчлэн эдгээр дотоод бүтцийн байгууллагуудын бүрэлдэхүүнийг өөрчлөх, намаас хууль тогтоох дээд байгууллагад нэр дэвшигчдийг сонгоход гишүүдийн оролцоо ямар түвшинд байгааг тодрууллаа. Өрсөлдөөн хэмжигдэхүүн нь нийт 24 хүртэлх оноотой байна.

Зураг 5. Улс төрийн нам доторх өрсөлдөөн, 2019-2020 он (24 оноо)



Нам доторх өрсөлдөөн хэсэгт судалгаанд оролцсон дөрвөн намын дундаж оноо 2020 онд нийт 24 онооноос 12 байна. 2020 он сонгуулийн жил тул намууд сонгуульд

нэр дэвшигчээ тодруулах үйл явц өрнөсөн бөгөөд сонгуулийн бүх тойрогт нэр дэвшигч тодруулсан МАН, АН-д нэр дэвших өрсөлдөөн өндөр байв. Хоёр томоохон нам доторх

өрсөлдөөн харьцангуй хүчтэй байсан бөгөөд зөвхөн УИХ-ын сонгуульд нэр дэвшигчид ч биш намын дотоод шийдвэр гаргах албан тушаалуудад нэр дэвшигчдийн тоо өндөр байв.

Гэвч нэр дэвшигчдэд мөнгөн болон мөнгөн бус шалгуур тавигдсан учир тус хэмжигдэхүүнээр хамгийн бага оноог авчээ. Иймд шударга өрсөлдөөнд мөнгө хамгийн том саад тотгор болж буй хүчин зүйл гэдгийг энд дурдах ёстой. Тухайлбал АН-ын хувьд нэр дэвшигчдэд 100 сая төгрөгийн дэнчин тогтоосон байна. Харин МАН-ын хувьд УИХ-д нэр дэвшигчдээ тодруулахдаа намын дотоод судалгааны үр дүн буюу


мөнгөн бус шалгуурт үндэслэжээ. Мөн УИХ-ын сонгуулийн дараа төв намаас орон нутгийн намын даргыг сонгоход чиглэл өгч байсан нь нам доторх өрсөлдөөнийг хязгаарласан үйлдэл болжээ. Харин МАХН, ХҮН-уудын хувьд нэр дэвшигчийг тодруулах үйл явцдаа харьцангуй нээлттэй, өрсөлдөөн бага байжээ. МАХН-ын дарга тус нам 2011 онд үүсгэн байгуулагдсан цагаас хойш огт солигдоогүй буйг энд дурдах ёстой. Мөн тус намын удирдах зөвлөл өнгөрсөн дөрвөн жилд солигдоогүй байна.

ТӨЛӨӨЛӨЛ

Энэхүү хэмжигдэхүүнээр сонгуульд нэр дэвшигчдийг тодруулах болон намындотоод бүтцийн байгууллагуудад нийгмийн бүлгүүдийн төлөөллийг хэрхэн хамруулж буйг шинжлэв. Намын гол шийдвэрүүдийг гаргах албан тушаал, болон хууль тогтоох дээд байгууллагад нэр дэвшигчдэд эзлэх залуучууд, эмэгтэйчүүдийн хувь

хэмжээнд үнэлэлт өглөө. Тухайлбал, сонгуульд нэр дэвшигчдэд эзлэх эмэгтэйчүүдийн хувь хэмжээг зөвхөн сонгуулийн хуулийн шаардлагад нийцүүлэх бус сайн дурын хувь хэмжээг тогтоодог эсэхийг шинжиллээ. Төлөөлөл хэмжигдэхүүн нь нийт 16 хүртэлх оноотой байна.

Зураг 6. Улс төрийн намын төлөөлөл, 2019-2020 он (16 оноо)



Улс төрийн намын төлөөлөл хэсэгт судалгаанд оролцсон дөрвөн нам нийт 16 онооноос дунджаар 9.6 оноог энэ онд авчээ. МАН болон АН нь залуучуудын, эмэгтэйчүүдийн, оюутны

болон ахмадын холбоо зэрэг дотоод төлөөллийн байгууллагуудтай учир тус хэмжигдэхүүнээр өндөр оноо авсан. Улс төрийн томоохон хоёр намын хувьд залуучууд, эмэгтэйчүүдийн албан ёсны

төлөөллийн байгууллагатай хэдий ч эдгээр байгууллагуудын намын гол чиг үүрэгт эзлэх нөлөөлөл хязгаарлагдмал байна. Мөн намууд эмэгтэйчүүдийн холбоондоо хүрэлцэхүйц санхүүгийн дэмжлэг үзүүлдэггүй байна. Судалгаанд оролцогчид намаас хангалттай санхүүжилт олгодоггүй учир уг холбооны удирдах зөвлөлийн гишүүд хувиасаа өдөрт тутмын үйл ажиллагаагаа санхүүжүүлдэг гэдгийг хэлж байв. Харин МАХН дотоод төлөөллийн байгууллагуудынхаа үйл ажиллагааг зогсоосон байна. ХҮН-ын хувьд зөвхөн


залуучуудын байгууллагатай бөгөөд тус байгууллагын удирдлагыг намын дарга нь томилсон байна. МАХН, ХҮН нь УИХ-д нэр дэвшигчиддээ сайн дураар 30 хувийн жендерийн квотыг тогтоосон бол АН, МАН хуульд заасан 20 хувийн квотдоо дөнгөж хүрчээ. Судалгаанд оролцогчид залуучууд, эмэгтэйчүүдийн оролцоо анхан болон дунд шатанд харьцангуй идэвхтэй байдаг гэдгийг дурдаж байв. Гэвч өмнө нь дурдсан шалтгаануудын улмаас дээд түвшин дэх оролцоо хангалтгүй байна.

ИЛ ТОД БАЙДАЛ (САНХҮҮЖИЛТ)

Энэхүү хэсэгт улс төрийн намын ил тод байдал, тэр дундаа санхүүжилтийн ил тод байдлыг шинжилсэн. Улс төрийн намууд олон нийтийн байгууллага учраас үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа гаргаж гишүүддээ болон олон нийтэд тайлагнах үүрэгтэй. Олон нийтэд тайлагнахаас гадна намын ерөнхий түвшинд болон нэгжийн түвшинд

гишүүддээ тайлагнах зэргээр ялгаатай байгааг судаллаа. Мөн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, вэб сайтуудад намынхаа мэдээллийг хэр зэрэг ил тод харуулж байгааг мониторинг байдлаар шалган намын дүрэм, намын мөрийн хөтөлбөр, намын дүрэм, журмууд, намын гишүүдийн мэдээлэл зэрэг нийт 9 шалгуурын хүрээнд дүгнэсэн.

Зураг 7. Улс төрийн намын ил тод байдал, 2019-2020 он (35 оноо)



Намын ил тод байдал хэсэгт 2020 онд судалгаанд оролцсон дөрвөн намын дундаж оноо нийт 35 онооноос 22.5 байна. ХҮН сүүлийн 3

жил дараалан санхүүгийн тайлангаа олон нийтэд тайлагнажээ. МАН, АН, МАХН-уудын хувьд санхүүгийн үйл ажиллагааг жилдээ нэг удаа гишүүдэд

тайлагнадаг гэж хариулсан. Гэвч УТНТХ-д заасан үүргээ гүйцэтгэхгүй байсаар байна. Өөрөөр хэлбэл намуудын санхүүжилтийн ил тод байдал хангагдахгүй байсаар байна. МАХН санхүүгийн тайлангаа гишүүддээ мэдээллээгүй учир тус намын оноо өнгөрсөн жилтэй харьцуулахад

ихээхэн буурсан. Судалгаанд оролцсон бүх намууд албан ёсны вебсайт, нийгмийн сүлжээний хуудсуудтай байна. Эдгээр вебсайт, нийгмийн сүлжээний хуудсуудад мониторинг хийхэд МАН, МАХН, АН санхүүгийн тайлангаа байршуулаагүй байв.

ДҮГНЭЛТ

Улс төрийн намуудын дотоод ардчиллын индексийг тодорхойлох судалгааг оролцоо, өрсөлдөөн, ил тод байдал, санхүүжилт гэсэн дөрвөн гол үзүүлэлт тус бүрт судалгааны арга зүйн дагуу тодорхой оноо өгөн дүгнэсэн болно. Израилын Ардчилал институт Намын дотоод ардчиллын индексээр намуудын дотоод ардчиллыг дараах байдлаар гурав ангилдаг. Тухайлбал 1) 61 - 100 оноо авсан бол ардчилалтай нам, 2) 31 - 60 оноо авсан бол хагас ардчилалтай нам, 3) 30 хүртэлх оноо авсан бол ардчилалгүй нам зэргээр ангилдаг. Дээрх ангиллаар 2020 оны Монголын улс төрийн намуудын дотоод ардчиллын индекс судалгаанд хамрагдсан дөрвөн намын гурван нь буюу МАН, АН, МАХН-ууд “хагас ардчилсан” гэдэг ангилалд хамрагдаж байна. Харин Хөдөлмөрийн Үндэсний нам “ардчилалтай нам”-д хамаарах үнэлгээг авлаа. Үүнд намын гишүүдээс авсан асуулгаар нийт 100 онооноос:

1. ХҮН – 69.6 оноо
2. АН – 57.6 оноо
3. МАХН – 57.5 оноо
4. МАН – 53.9 оноог тус тус авлаа.

Улс төрийн намуудын авсан онооны хооронд зөрөө их гараагүй, дотоод ардчиллын түвшин тун ойролцоо буюу хангалтгүй түвшинд байна. Улс төрийн намуудын дотоод ардчиллын индексийг тодорхойлох судалгаанд хамрагдсан намуудыг авсан оноогоор дүгнэж болох ч оролцоо, өрсөлдөөн, төлөөлөл, ил тод байдал гэсэн дөрвөн үзүүлэлт тус бүр дээр нам бүрийн авсан оноо харилцан адилгүй, өөрчлөлттэй гарсныг анхаарах хэрэгтэй. МАН, АН, МАХН-ын оноо өмнөх жилээс 1-8.5 оноогоор буурсан бол ХҮН-ын оноо 6.6-гоор нэмэгджээ. Энэ нь улс төрийн намуудын сонгуульд нэр дэвшигчдээ тодруулах үйл явц, өрсөлдөөн, гишүүдийн оролцоо, ил тод байдал зэрэгтэй шууд хамааралтай юм. Намын дарга эсвэл даргын дэмжлэгийг авсан баг нэр дэвшигчдийг тодруулах зэрэг шийдвэр гаргалтад гол үүрэг гүйцэтгэж байгаа нь дотоод ардчиллын хувьд асуудалтай гэж үзсэн болно. АН дотоод ардчиллын оноо унасан нь нам доторх өрсөлдөөнд дотоод ардчилалд сөрөг нөлөөтэй кэйсүүд гарч намын дүрэм зөрчигдсөнтэй холбоотой. Хэдийгээр орон нутгийн намын гишүүд сонгуульд нэр дэвшигчдээ санал болгох, дэвшүүлэх эрхтэй ч шийдвэр гаргах

эрх мэдэл төв намд хадгалагдаж байна. МАН-ын тухайд ч ижил дүр зураг ажиглагдав.

Мөн намын мөрийн хөтөлбөр, бодлого боловсруулалтад ойролцоо үйл явц ажиглагдав. Намууд бодлого боловсруулах үйл явцдаа харьцангуй олон тооны гишүүдийг оролцуулж буй ч түүнийг батлах эцсийн шийдвэр нь цөөн тооны гишүүдээр хязгаарлагдаж байна. Х эдийгээр 2020 он сонгуулийн жил байсан ч намууд дотроо бодлогын мэтгэлцээн, хэлэлцүүлэг зохион байгуулаагүй байна. АН намын даргаа сонгохдоо хамгийн хүртээмжтэй буюу нийт гишүүдийн саналаар сонгож байгаа бол МАХН намын даргаа үүсгэн байгуулагдсанаас хойш огт солиогүй байна.

МАН, АН-аас судалгаанд оролцогчид хуулийн дагуу эмэгтэйчүүдийн 20 хувийн квотыг арай л гэж хангасан гэдгээ хүлээн зөвшөөрч байсан. Ялангуяа Ардчилсан намын тухайд нэр дэвшигчдэд “дэнчин” гэсэн хаалт тавьсан байсан. Хэдийгээр тэд эрэгтэйчүүдэд 100 сая, эмэгтэйчүүд 60 сая төгрөг гэж ялгаатай тогтоосон байсан ч гэсэн эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны хувьд саад,

бэрхшээл гэж үзэж болохоор байна. МАН хувьд нэр дэвшигчдийг тодруулах процесс нь намынхаа дотоод судалгаанд суурилж хийгдсэн бөгөөд энэ нь оролцоог хангах тал дээр учир дутагдалтай байв. Мөн уг үйл явцийг төв намаас дангаар хэрэгжүүлсэн нь ил тод байдлыг хангаагүй, намын орон нутгийн салбаруудын оролцоо хязгаарлагдмал байжээ. Томоохон улс төрийн намууд нэр дэвшигчдийг тодруулах процесст намын даргын нөлөөлөл ихтэй, хаалттай байна. Мөн судалгаанд оролцогчдын хариулснаар МАН, АН-д намын анхан болон дунд шатанд эмэгтэйчүүдийн оролцоо өндөр байна. Гэвч дээд шатанд эмэгтэйчүүдийн оролцоо мөнгөн болон мөнгөн бус босго тогтоосны улмаас хангалтгүй байна. МАХН болон ХҮН сонгуульд нэр дэвшигчдээ тодруулахад сайн дурын 30%-ийн квот тогтоосон хэдий ч УИХ-д хангалттай тооны гишүүд сонгогдоогүй учир эмэгтэйчүүдийн төлөөллийг хангахад хязгаарлагдмал байна. МАХН-ын хувьд мөн адил 2020 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийг тодруулах үйл явцад намын дарга ихээхэн нөлөөтэй оролцсон байна.

ХҮН санхүүгийн тайлангаа сүүлийн 3 жил бүр өөрийн вэбсайтаар олон нийтэд тайлагнасан. Энэ нь ил тод байдлын хувьд бусдаасаа илүү оноо авах нөхцөлийг бүрдүүлсэн. Гэвч ХҮН болон МАХН-ын хувьд төлөөлөл хэсэгт хамгийн бага оноотой байна. МАХН-ын хувьд оюутнууд, залуучууд, эмэгтэйчүүдийн зэрэг дотоод төлөөллийн байгууллагуудынхаа үйл ажиллагааг зогсоосноор энэ хэсэгт ихээхэн оноо алдахад хүрсэн. Харин ХҮН зөвхөн залуучуудын байгууллагатай бөгөөд дарга нь намын удирдлагаас томилогддог байна. МАН болон АН ахмадын, эмэгтэйчүүдийн, оюутнуудын, залуучуудын зэрэг дотоод төлөөллийн байгууллагатайгаараа төлөөлөл хэсэгт хамгийн өндөр оноотой байна.

Энэхүү судалгааг 2020 оны 6 болон 10-р сард зохион байгуулагдсан УИХ, орон нутгийн сонгуулийн дараагаар хийж гүйцэтгэв. Уг судалгаанд эрх баригч нам хамгийн бага оноотой байгаа ч УИХ-д үнэмлэхүй олонхийг бүрдүүлж байгаа нь намын дотоод

ардчилал сонгуулийн амжилттай шууд хамааралгүй гэдгийг илтгэнэ. Гэвч эрүүл ардчилсан тогтолцоог бүрдүүлэх, олон ургалч, хүртээмжтэй байдал, төлөөллийг хангахад намын дотоод ардчилал нь чухал ач холбогдолтой юм. Намын дотоод ардчиллын сайн туршлагатай намуудад олон нийтийн итгэх итгэл өндөр гэдгийг мөн энд тэмдэглэх нь зүйтэй. Сант марал сангийн судалгаагаар аль нэг намыг онцолж үздэг гэж хариулсан хүмүүсийн тоо сүүлийн 10 жилд буурсаар байна. Тухайлбал 2010 онд судалгаанд оролцогчдын 45% нь аль нэг намыг илүүд үздэг гэж хариулсан бол энэ тоо 2020 онд ердөө 26% болж буурсан нь намуудын үйл ажиллагаа олон нийтэд нийцэхгүй байгааг харуулж байна (Сант Марал Сан, 2010-2020).

Эцэст нь намын дотоод ардчиллын 2020 оны индексийн үр дүнгээр улс төрийн намууд дотоод ардчиллаа ихээхэн сайжруулах шаардлагатайг илтгэнэ. Намууд дотоод ардчиллаа бэхжүүлэхэд дараах зөвлөмжүүдийг хүргэж байна.

- I) Намын шийдвэр гаргах үйл явц тэр дундаа сонгуульд нэр дэвшигчдийг тодруулахад мөнгөн болон мөнгөн бус босгыг халах;
- II) УТНТХ-ийн дагуу санхүүгийн тайлангаа нээлттэйгээр тогтмол тайлагнах;
- III) Намын дотоод дүрмийн биелэлтийг хангах замаар намын гишүүдэд тэгш, тодорхой нөхцлийг бий болгох;
- IV) Сонгуульд нэр дэвшигчид болон намын шийдвэр гаргах албан тушаалууд, дотоод төлөөллийн байгууллагууд дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхийн тулд сайн дурын жендерийн квот ашиглах;
- V) Намын залуучууд, эмэгтэйчүүдийн төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх, хангалттай санхүүгийн нөөцөөр хангах;
- VI) Нэр дэвшигчдийг тодруулах үйл явцад намын гишүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх;
- VII) Намын хөтөлбөр, бодлого боловсруулахад гишүүдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд бодлогын мэтгэлцээн, хэлэлцүүлгүүдийг тогтмол зохион байгуулах.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- ACE (2018) Youth & Elections. The Electoral Knowledge Network, Available at <https://aceproject.org/ace-en/topics/yt/yt10/yt210/young-people-in-political-parties>
- Ballington, J. (2004) Strengthening Internal Political Party Democracy: Candidate Recruitment from a Gender Perspective
- Bat-Ulzii, E (2015) Political Party Financing: International Practices & Challenges in Mongolia
- Cross, W. & Katz, R. S. (2013) The Challenges of Intra-Party Democracy, Oxford, Oxford University Press
- Diamond, L. & Gunther, R. (2001) Parties and Democracy, Prince University Press.
- Dix, R (1992). 'Democratization and the Institutionalization of Latin American Political Parties', Comparative Political Studies, 24:4, 488-511.
- Casal Bértoa, F. (2011). Sources of party system institutionalization in new democracies: lessons from East Central Europe.
- Gauja, A. (2009) Internal Party Democracy and Policy Formulation: Rationales, Trends, Relevance
- Gerelt-Od, E. (2009) Challenges of Internal Democracy in Mongolian Political Parties (since 1990)
- Inter-Parliamentary Union, (2020) Global & Regional Averages of Women in National Parliaments. Available at <https://data.ipu.org/women-averages>
- Inter-Parliamentary Union, (2018) Youth Participation in National Parliaments. Available at <https://www.ipu.org>
- LeDuc, L. & Nieme, R. G. (1996) Comparing Democracies: Elections and Voting in Global Perspectives
- Lijphart, A. (2008) Patterns of Democracy: Government Forms and Performance in Thirty-Six Countries /translation/
- Mainwaring, and Scully (1995). Building Democratic Institutions: Party Systems in Latin America. Stanford: Stanford University Press.

- Norris, P. (2004) Building Political Parties: Reforming Legal Regulation and Internal Rules
- Rahat, G. & Shapira, A. (2016) An Intra-Party Democracy Index: Theory, Design & A Demonstration
- Schattschneider, E. E. (1942). Party Government. New York: Farrar and Rinehart. Inc.
- Sant Maral Foundation (2010 - 2019) Politbarometer, Ulaanbaatar, Mongolia
- The International Republican Institute, (2020) National Survey of Mongolian Youth. Available at https://www.iri.org/sites/default/files/mongolia_ned_youth_poll_2020_-_public_0.pdf
- The Asia Foundation, (2017) Survey on Perceptions and Knowledge of Corruption
- Transparency International (2007), Global Corruption Barometer
- Von dem Berge, B., Poguntke, T., Obert, P. & Tipei, D. (2013) Measuring Intra-Party Democracy

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Парламентад 30, 40, 45-аас доош насны төлөөлөлтэй улсууд /бүс нутгаар/

30 наснаас доош			40 наснаас доош			45 наснаас доош		
Бүс нутаг	Хувь	Улсууд	Бүс нутаг	Хувь	Улсууд	Бүс нутаг	Хувь	Улсууд
Европ	3.9	47	Европ	23.5	47	Европ	37.5	47
Америк тив	3.8	23	Америк тив	19.2	23	Америк тив	33.8	23
Африк тив	1.5	36	Африк тив	15.0	36	Африк тив	29.4	36
Далайн орнууд	1.2	33	Далайн орнууд	12.7	8	Далайн орнууд	27.6	8
Ази	0.4	8	Ази	10.8	33	Ази	21.6	33
Нийт	2.2	147	Нийт	15.5	147	Нийт	28.1	147

Хавсралт 2. Парламентын сонгуульд залуусын квот хэрэглэдэг улс орнууд

Улс	Квотын хэлбэр	Насны хязгаар	Квот %	Жендэр	30-аас доош насны эзлэх хувь	40-аас доош насны эзлэх хувь
Руанда	Суудал хадгалах	35 доош	7.7	Тусгасан	1.3	22.5
Марокко	Суудал хадгалах	40 доош	7.6	Тусгасан	1.6	14.7
Кени -Доод танхим	Суудал хадгалах	35 доош	3.4	Тусгасан	-	-
Кени - Дээд танхим	Суудал хадгалах	35 доош	2.9	Тусгасан	3.0	26.9
Уганда	Суудал хадгалах	30 доош	1.3	Тусгасан	1.1	22.9
Филиппин	Нэр дэвшигч	-	50*	Холимог	1.7	15.8
Тунис	Нэр дэвшигч	35 доош	25**	Тусдаа	6.5	22.6
Габон	Нэр дэвшигч	40 доош	20	-	0.0	8.6
Киргиз	Нэр дэвшигч	36 доош	15	Тусдаа	4.2	35.0

Улс	Квотын хэлбэр	Насны хязгаар	Квот %	Жендэр	30-аас доош насны эзлэх хувь	40-өөс доош насны эзлэх хувь
Египет	Нэр дэвшигч	35 доош	Олон төрөл****	Тусдаа	1.0	11.8
Никарагуа	Сайн дурын	-	40,*** 15	Холимог	1.1	14.1
Румын	Сайн дурын	-	30	Тусдаа	6.4	35.3
Мексик	Сайн дурын	35 доош	30, 20	Тусдаа	7.6	35.7
Монтенегро	Сайн дурын	35 доош	30, 20	Тусдаа	9.9	30.9
Вьетнам	Сайн дурын	40 доош	26.5	Тусдаа	1.8	12.3
Эл сальвадор	Сайн дурын	31 доош	25	Тусдаа	2.4	14.3
Швед	Сайн дурын	35 доош	25	Тусдаа	12.3	34.1
Мозамбик	Сайн дурын	35 доош	20	Тусдаа	0.0	17.2
Кипр	Сайн дурын	35 доош	20	Тусдаа	1.8	12.5
Литва	Сайн дурын	35 доош	-	Тусдаа	2.8	19.2
Унгар	Сайн дурын	-	20	Тусдаа	2.0	29.4
Сенегал	Сайн дурын	-	20	Тусдаа	0.0	11.0
Ангол	Сайн дурын	-	15	Тусдаа	0.6	11.1
Турк	Сайн дурын	-	10	Тусдаа	0.2	8.8
Хорват	Сайн дурын	-	-	Тусдаа	2.7	21.9
Украин	Сайн дурын	-	-	Тусдаа	5.0	41.2

Хавсралт 3. Орон нутгийн сонгуульд залуусын квот хэрэглэж байгаа орнууд

Улс	Квотын хэлбэр	Насны хязгаар	Квотын зохицуулалт	Жендэрийн харьцаа
Уганда	Суудал хадгалах	30 наснаас доош	Орон нутгийн хуралд 4 суудал	4 суудлын 2 нь эмэгтэй байх
Зүүн Тимор	Суудал хадгалах	30 наснаас доош	Тосгоны зөвлөл бүр 2 суудал	1 эрэгтэй, 1 эмэгтэй
Шриланк	Нэр дэвшигч	35 наснаас доош	Эмэгтэйчүүд, залуус холимог байдлаар 25%	Эмэгтэйчүүд, залуус холимог байдлаар 25%
Тунис	Нэр дэвшигч	35 наснаас доош	Эхний 3 нэр дэвшигч тутмын нэг; түүнээс хойшхи 6 нэр дэвшигч тутамд дахин нэг	Хуулиар нэр дэвшигчийн жагсаалтад жендэрийн харьцааг барихыг шаарддаг
Перу	Нэр дэвшигч	30 наснаас доош	Намын нэр дэвшигчдийн 20 %	30 % жендэрийн квот тусдаа хуулиар зохицуулна.

